



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/09

Бат-Өлзий сум

Эцэг, эхийн зөвлөлийг шинэчлэн
байгуулах тухай

Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3, 26 дугаар зүйлийн 26.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 17 дугаар зүйлийн 17.1.2, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд эцэг эхийн зөвлөл байгуулж ажиллах зөвлөмж”-ийн 2.2, 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын Эцэг, эхийн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн дарга: О.Отгонтуяа (Төсвийн ерөнхий нягтлан бодогч)
Нарийн бичгийн дарга: Г.Хорол-Эрдэнэ (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын мэргэжилтэн)

Гишүүд: Ж.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)
Г.Бямбагарав (5 дугаар багийн Засаг дарга)
Г.Доржханд (Хууль эрх зүйн мэргэжилтэн)
Ө.Гэлгөө (Улсын бүртгэгч)
Г.Дуламдорж (Насан туршийн боловсролын арга зүйч)

2. Засаг даргын Тамгын газрын дэргэдэх “Эцэг, эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагааг тогтворжуулан зөвлөмжийг мөрдөж, төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг зохион байгуулж, тайланг жилийн бүрийн 12 дугаар сарын 01-ны дотор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүлж ажиллахыг Зөвлөлийн дарга (О.Отгонтуяа)-д даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Эцэг, эхийн зөвлөл байгуулах тухай” сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/17 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.



ДАРГА

Н.БАТ-ЭРДЭНЭ